



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/188

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн "Сумын 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Төв хогийн цэгийг булах, цэвэрлэх" ажилд зарцуулагдах санхүүжилт 4502700 (дөрвөн сая таван зуун хоёр мянга долоон зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. "Төв хогийн цэгийг булах, цэвэрлэх" ажилд зарцуулагдах санхүүжилт 4502700 (дөрвөн сая таван зуун хоёр мянга долоон зуу) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (М.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ